

Энэхүү орчуулга нь 2017 оны 10 дугаар сарын 9-ний Төслийн мэдээллийн тайлангийн англи эхэд суурилсан болно.



ASIAN DEVELOPMENT BANK

Монгол Улс: Аймгийн болон сумын төвүүдийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (хуучнаар: Монгол улсын хоёрдогч хотууд болон сумын төвүүдийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр)

Төслийн нэр	Аймгийн болон сумын төвүүдийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (хуучнаар: Монгол Улсын хоёрдогч хотууд болон сумын төвүүдийн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр)	
Төслийн дугаар	49430-005	
Төсөл хэрэгжих улс	Монгол Улс	
Төслийн статус	Боловсруулж буй	
Төслийн төрөл / Тусламжийн хэлбэр	Зээл	
Санхүүжилтийн эх үүсвэр / Мөнгөн дүн	Олон шатлалт санхүүжилтийн хэрэгслийн зарчим: Аймгийн болон сумын төвүүдийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр	
	Хөнгөлттэй ердийн хөрөнгийн эх үүсвэрийн зээл /Азийн хөгжлийн сан/	134.00 сая ам.доллар
	Ердийн хөрөнгийн эх үүсвэр	226.00 сая ам.доллар
Холбогдох стратегийн зорилт	Байгаль орчинд ээлтэй тогтвортой өсөлт Эдийн засгийн хүртээмжтэй өсөлт Бүсийн интеграц	

Өөрчлөлтийг чиглүүлэгч салбарууд	Засаглал ба чадавхийн хөгжил Мэдлэгт суурилсан шийдэл Түншлэл Хувийн хэвшлийн хөгжил
Салбар / Дэд салбар	<p>Үйлдвэрлэл ба худалдаа - Үйлдвэрлэл ба худалдааны салбарын хөгжил – Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил</p> <p>Зам тээвэр - Авто замын тээвэр (орон нутгийн) - Хотын авто зам ба замын хөдөлгөөний менежмент</p> <p>Ус болон хотын бусад дэд бүтэц, нийтийн аж ахуйн үйлчилгээ - Хотын нийтийн аж ахуйн бусад үйлчилгээ – Хотын бодлого, бүтцийн болон чадавхийн хөгжил – Хотын ариутгах татуургын шугам сүлжээ – Хотын гэр хорооллын хөгжил - Хотын хуурай хог хаягдлын менежмент - Хотын усан хангамж</p>
Жендэрийн тэгш эрх ба жендэрийн үзэл баримтлалыг төлөвлөлт, үйл ажиллагаанд тусгах нь	Жендерийн тэгш байдлын үзэл баримтлалыг үр өгөөжтэй нэвтрүүлсэн
Төслийн тодорхойлолт	<p>Хөтөлбөр нь олон тулгуурт эдийн засаг, экологийн тэнцвэрт байдлыг хөгжүүлэх замаар илүү тогтвортой хөгжлийг Монгол Улсад бий болгоход үр нөлөө үзүүлнэ. Төслийн үр дүнд нийтийн аж ахуйн болон эдийн засгийн үйлчилгээ, байгууламж сайжирч зорилтот суурин бүсийн иргэд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд төслөөс үр ашгийг хүртэнэ. Төсөл хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (i) зорилтот газруудад хотын дэд бүтэц болон нийтийн аж ахуйн үйлчилгээ сайжирна, (ii) зорилтот газруудад эдийн засгийн дэд бүтэц болон байгууламж сайжирна, (iii) зорилтот суурин бүс дэх авто замын сүлжээ сайжирна, (iv) хөтөлбөрийн чадавхи болон институтын менежмент бэхжинэ.
Төслийн үндэслэл ба Улс/Бүс нутгийн стратегитай уялдсан байдал	<p>Хөтөлбөрийн зорилго нь зорилтот аймгийн болон сумын төвүүдэд нийтийн аж ахуйн суурь үйлчилгээг болон эдийн засгийг хөгжүүлэхэд оршино.</p> <p>Хөтөлбөр нь газарзүйн хувьд зорилтот хэсгүүдэд нэгдсэн арга барилаар хэрэгжих бөгөөд хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг бий болгох илүү уян хатан, олон тулгуурт эдийн засгийг хөгжүүлэх боломжтой тэргүүн ач холбогдолтой суурин бүсийн төвүүдэд төвлөрч ажиллана.</p>
Төслийн үр нөлөө	Хөтөлбөр нь олон тулгуурт эдийн засаг, экологийн тэнцвэрт байдлыг хөгжүүлэх замаар илүү тогтвортой хөгжлийг Монгол Улсад бий болгоход үр нөлөө үзүүлэх юм.
Төслөөс хүлээгдэж буй үр дүн	Төслийн үр дүнд нийтийн аж ахуйн болон эдийн засгийн үйлчилгээ, байгууламж сайжирч зорилтот суурин бүсийн иргэд болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд төслөөс үр ашиг хүртэнэ.

Төслийн үр дүн Зорилтот газруудад хотын дэд бүтэц болон нийтийн аж ахуйн үйлчилгээ сайжирсан байх, Зорилтот газруудад эдийн засгийн дэд бүтэц болон байгууламж сайжирсан байх, Зорилтот суурин бүс дэх авто замын сүлжээ сайжирсан байх, Хөтөлбөрийн чадавхи болон институтын менежмент бэхжсэн байх.

Газарзүйн байршил

Хамгааллын бодлогын ангиллууд

Байгаль орчин Анхан шатны үнэлгээгээр төслийн байгаль орчны асуудлыг В ангилалд хамааруулсан. Байгаль орчны анхан шатны шинжилгээ, үнэлгээ, хяналтыг 2009 оны "АХБ-ны Хамгааллын бодлогын баримт бичиг"-ийн дагуу боловсруулж АХБ-ны цахим хуудсаар нийтэд ил болгоно. Цаг уурын эрсдэл, өртөмтгий байдлын үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Албадан нүүлгэн шилжүүлэлт Анхан шатны үнэлгээгээр төслийн албадан нүүлгэн шилжүүлэлтийн асуудлыг В ангилалд хамааруулсан. Нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлэх нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн нүүлгэн шилжүүлэлтийн цар хүрээг боловсруулна.

Уугуул иргэд Анхан шатны үнэлгээгээр төслийн уугуул иргэдийн асуудлыг С ангилалд хамааруулсан. Зорилтот бүсийн хүн амын дунд хийсэн анхан шатны үнэлгээгээр хөтөлбөрийн нэгдүгээр үе шатанд аливаа үндэсний цөөнх бүлэг нөлөөлөлд өртөхгүй. Техник туслалцааны хэрэгжилтийн явцад үүнийг баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд уугуул иргэдийн хувьд хэрэгжүүлэх төлөвлөгөөний цар хүрээг боловсруулна.

Оролцогч талуудын харилцаа, оролцоо ба хэлэлцүүлэг

Төслийн төлөвлөлтийн үед

Төслийн хэрэгжилтийн үед

Хариуцагч талууд

АХБ-ны хариуцсан ажилтан Арно Хекман

АХБ-ны хариуцсан газар Зүүн Азийн Газар

АХБ-ны хариуцсан хэлтэс Хот байгуулалт ба нийгмийн салбарын хэлтэс

Хэрэгжүүлэгч байгууллага **Барилга, хот байгуулалтын яам**
Улаанбаатар 211238
Барилгачдын талбай 3, Монгол Улс

Цагалбар

Төслийн үзэл баримтлалыг батлах	2017 оны 9 дүгээр сарын 12
Баримт цуглуулах, судалгаа хийх	2018 оны 4 дүгээр сарын 24-нөөс 2018 оны 5 дугаар сарын 20
Удирдлагын хянан хэлэлцэх хурал	2018 оны 12 дугаар сарын 7
Төслийг батлах	-
Сүүлд хийгдсэн төслийн хэрэгжилтийн хяналт	-
Төслийн мэдээллийн тайланг шинэчилсэн огноо	2017 оны 9 дүгээр сарын 14

Төслийн Мэдээллийн Тайлан (ТМТ)-д төсөл, хөтөлбөрийн талаарх хураангуй мэдээлэл агуулагддаг бөгөөд энэхүү тайлан нь тогтмол шинэчлэгддэг тул зарим нэг мэдээлэл тайлангийн эхний хувилбарт багтаагүй ч дараачийн хувилбарт орж болно. Төлөвлөж буй (батлагдаагүй) төслийн талаарх мэдээлэл нь урьдчилсан бөгөөд тойм шинж чанартай.

АХБ нь энэхүү ТМТ–г хэрэглэгчдэд гагцхүү мэдээллийн чанартай хүргэж байгаа бөгөөд ямарваа баталгааг олгохгүй. АХБ-ны зүгээс агуулгын чанарт ихээхэн анхаардаг хэдий ч энэхүү тайланд агуулагдсан мэдээллийг “байгаагаар нь” буюу арилжааны шаардлагыг хангах, тодорхой зорилгоор ашиглахад нийцэх эсвэл бусдын эрхэнд халдахгүй байх гэх мэт ямарваа нэгэн шууд болон шууд бус баталгааг өгөхгүйгээр толилуулж байна. АХБ нь тайлан дахь мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлын талаарх ямар нэгэн баталгаа, эсхүл мэдэгдэл хийгээгүй болно.